

Цэргийн штабын тайлан 2013

Бичсэн .

2014 оны 3-р сарын 04, Мягмар гариг, 08:31 - Сvvлд шинэчлэгдсэн 2014 оны 3-р сарын 04, Мягмар гариг, 08:32

ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ЦЭРГИЙН ШТАБЫН 2013 ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Нэг. Батлан хамгаалахын сайд, аймгийн Засаг даргын бодлогын зорилт, төлөвлөлтийн хэрэгжилтийн талаар:

Тус аймгийн Цэргийн штаб нь аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтцэд орж, Засаг даргын удирдлагын дор үйл ажиллагаагаа явуулж байна.

Ховд аймгийн цэргийн штаб нь холбогдох хууль тогтоомжууд, Засгийн газрын үйл ажиллагааны морийн хотолбор, Батлан хамгаалах сайдын болон Зэвсэгт хүчний жанжин штабын даргын тушаал, заавар, цэргийн шинэчлэлийн бодлогыг удирдлага болгож 2013 оны зорилго, зорилтоо тодорхойлж, дэвшүүлэн үйл ажиллагаандаа тусган бүрэн хэрэгжүүлж ажилаллаа.

Засгийн газрын үйл ажиллагааны хотолборт Батлан хамгаалах чиглэлээр тусгагдсан зорилт, арга хэмжээг орон нутагт хэрэгжүүлэх, сурталчлах, биелэлтэнд хяналт тавих, мэргэжлийн удирдлагаар хангах үйл ажиллагааг авч хэрэгжүүллээ.

Цэргийн штаб нь жилийн үйл ажиллагааны ажлын тоолоогоог сум, агентлагууд, аж ахуйн нэгж, байгууллагуудын тоолоогоотэй уялдуулан боловсруулж, тухай бүр тодотгон, биелэгдэх бололцоо нохцол, арга замыг хангахад гол анхаарлаа чиглүүлэн ажилласан.

Цэргийн штаб нь ажлаа Засаг даргын Тамгын газрын даргатай үр дүнгийн гэрээ байгуулан, 7 хоног, сар, улирлаар тооловон, түүнийгээ мөрдлөг болгон ажиллаж биелэлтийг тооцож ажиллав.

2013 оны жилийн тоолоогоо, Торийн алба хаагчийн үр дүнгийн гэрээ, ажлын байрны тодорхойлолтуудыг гаргаж батлуулан, Монгол Улсын торийн албан хаагчдын эрхэмлэх

Цэргийн штабын тайлан 2013

Бичсэн .

2014 оны 3-р сарын 04, Мягмар гариг, 08:31 - Сvvлд шинэчлэгдсэн 2014 оны 3-р сарын 04, Мягмар гариг, 08:32

есон зvйл, Ховд аймгийн торийн алба хаагчийн одор тутам мордох ёс зvйн зарчмыг эрхэмлэн ажилласан.

Засаг даргын цаг vеийн ажлын чиглэлээр хийгддэг аймгийн шуурхай зовлогоо, ЗДТГ-ын шуурхайд цэргийн штабын ажлын талаар мэдээлж, байгууллагын удирдлагуудад чиглэл, vvpрэг даалгавар огч, биелэлтийг хангуулан, Батлан хамгаалах хууль, тогтоомжуудад заагдсан удирдлага, толовлолтийн баримт бичгvvдийг Засаг даргатай зовшилцон боловсруулж, хэрэгжилтэнд хяналт тавин ажилласан.

Аймгийн Засаг даргын захирамж 8, Засаг даргын тамгын газрын даргын тушаал 2, цэргийн штабын даргын тушаал 2 гарч биелэлт 100%-тай хэрэгжсэн.

Монгол Улсын торийн ёслолын арга хэмжээ болон Зэвсэгт хvчний еронхий командлагчыг орон нутагт айлчлах вeд хvлээж авах хvндэтгэлийн арга хэмжээг Зэвсэгт хvчний 123 дугаар анги болон орон нутгийн удирдлагуудтай хамтран зохион байгуулсан.

Зэвсэгт хvчний 123 дугаар ангийн хvндэтгэлийн арга хэмжээнд зориулж Засаг даргын нооцоос 7 000 000 тогрог гаргаж хивс авч огсон.

Хоёр: Батлан хамгаалах зорилт арга хэмжээ, Зэвсэгт хvчний шинэчлэлийн бодлогыг сурталчлах чиглэлээр:

Монгол Улсын Засгийн газраас Батлан хамгаалах болон Зэвсэгт хvчний талаар явуулж байгаа шинэчлэлийн бодлогыг орон нутагт, ард иргэдэд сурталчлах ажлыг тvvхт ойн баярын одрvvдээр Зэвсэгт хvчний 123 дугаар ангитай хамтран зохион байгуулан явуулж хэвшсэн.

Баруун бvсийн шинэ дайчдын цэргийн тангараг оргох ёслолын арга хэмжээг Ховд аймгийн “Ард Аюуш”-ийн талбайд Зэвсэгт хvчний 123, 340 дvгээр ангийн бие бvрэлдэхvвнтэй хамтран хийж, орон нутгийн ард иргэдэд цэргийн алба хаагчдын жагсаал, гардан тулааны vзvvлэх тоглолт, хэсэгчилсэн урлагын тоглолт, энхийг дэмжих ажиллагааны vзvvлэх сургуулийг тогтмол vзvvлж байгаа нь тэднээс ондор vнэлэлт

Цэргийн штабын тайлан 2013

Бичсэн .

2014 оны 3-р сарын 04, Мягмар гариг, 08:31 - Сvvлд шинэчлэгдсэн 2014 оны 3-р сарын 04, Мягмар гариг, 08:32

авсаар байна.

Тангараг оргох ёслолын арга хэмжээнд Батлан хамгаалахын дэд сайд А.Баттор, Ховд аймгийн Засаг дарга Д.Цэвээнравдан, цэргийн штабын дарга хурандаа Д.Бээжин, Увс аймгийн цэргийн штабын дарга хурандаа Д.Баатар-Эрдэнэ болон орон нутаг, сумын болон Үндэсний аюулгvй байдлыг хангах тусгайлсан чиг vврэг бvхий байгууллагын дарга нар ард иргэд, эцэг эхчvvдийн толоолол оролцов.

Тангараг оргох ёслолын арга хэмжээнд Улаанбаатар, Завхан, Увс аймгуудаас эцэг эхийн толоолол ирж оролцсон.

Зэвсэгт хvчний 92 жилийн ойн баярын нэрэмжит Үндэсний аюулгvй байдлыг хангах тусгайлсан чиг vврэг бvхий байгууллагуудын дунд дараахь тэмцээнvвдийг “Гар бомбог, сагсан бомбог, vндэсний бох, биллъярд, буудлага”-ын торлvvдээр явуулж Хилийн цэргийн 0130 дугаар анги Тэргvн байр эзэлж шилжин явах цом, алтан медаль, оргомжлол, монгон шагнал, Зэвсэгт хvчний 123 дугаар анги 2 дугаар байр эзэлж монгон медаль, оргомжлол, монгон шагнал, Шvvхийн шийдвэр гvйцэтгэх анги 3 дугаар байр эзэлж хvрэл медаль, оргомжлол, монгон шагналуудаар тус тус шагнагдсан.

Ховд аймгийн Жаргалант сумын 12 жилийн 7 сургууль, Политехникийн коллеж, аймгийн ЗДТГ-ын бие бvрэлдэхvн нийт 1075 хvнд “Монгол цэрэг-Дэлхийн цэрэг” сэдэвт лекц уншиж, дvрс бичлэгийн кино vзvvлж, тайлан мэдээг ЗХЖШ-ын ажиллагааны удирдлагын газрын Иргэн-цэргийн харилцааны хэлтэст хvргvвлсэн.

Батлан хамгаалах яамны гэрэл зурагчин МУСТА Б.Баярсайханы “Монгол цэрэг Энхийг дэмжих ажиллагаа”-нд оролцсоны 10 жилийн ойд зориулсан гэрэл зургийн vзэсгэлэнг “Үндэсний аюулгvй байдлыг хангах тусгайлсан чиг vврэг бvхий байгууллагууд”-ын албан хаагчид болон аймгийн ЗДТГ-ын албан хаагчид, ард иргэдэд vзvvлж сонирхуулсан.

Гурав: Орон нутагт, зохион байгуулж явуулсан хяналт шалгалтын талаар:

Цэргийн шинэчилсэн тоо бvртгэлийг Аймгийн Засаг даргын захирамж гаргаж 3 ve

Цэргийн штабын тайлан 2013

Бичсэн .

2014 оны 3-р сарын 04, Мягмар гариг, 08:31 - Сvvлд шинэчлэгдсэн 2014 оны 3-р сарын 04, Мягмар гариг, 08:32

шаттайгаар зохион байгуулан явуулж тайлан, мэдээг цаг хугацаанд нь БХЯ, ЗХЖШ-ын холбогдох газар хэлтэст хvргvүлсэн.

2013 оны 01 дvгээр сарын 04-ээс 07-ны одрvүдэд сумуудын ЗДТГ-ын дарга нартай “Торийн болон цэргийн нууцын аюулгvй байдлыг хангах арга зам” сэдэвт мэргэжил арга зvйн сургалтыг 3 хоногоор толовлон зохион байгуулан явуулж, 2012 оны ажлын дvнгээ гаргаж “Тэргvүн байр” эзэлсэн Монххайрхан сумын Засаг даргын Тамгын газрын дарга М.Бишгарамыг “Оргомжлол” монгон шагналаар шагнасан.

2013 оны 3 дугаар сарын 20-ны одор Жаргалант сумын 12 багийн дарга нарт “Цэргийн шинэчилсэн тоо бvртгэл” явуулах талаар 2 цагийн багтаамжтай сургалт зохион байгуулж, хамтран ажилласан.

Цэргийн шинэчилсэн тоо бvртгэлийн 2 дугаар зэргийн бэлтгэл vүрэгтнээс цэргийн алба хаагаагvй 30 хvртлэх насны залуучуудын нэрс гаргаж аймгийн Засаг даргын захирамж гаргуулан цэргийн албыг монгон толборийн хэлбэрээр хаалгаж торийн сангийн 160000983 тоот дансанд 102 иргэний 95 000 000 тогрогийг товлорvүлж Зэвсэгт хvчний хогжлийн санд шилжvүлсэн.

2013 оны цэргийн шинэчилсэн тоо бvртгэл явагдаж байгаатай уялдуулан орон нутаг дахь их, дээд сургууль, коллеж, 12 жилийн дунд сургуульд албан бичиг огч цэрэг алба хаагаагvй, бvртгэлгvй байсан цэргийн насны залуучуудыг бvртгэлд хамруулж авсан.

Аймгийн иргэний бvртгэлийн товтэй харилцан ажиллаж, цэргийн насны залуучуудын нэрсийг авч бvртгэлд хамруулж, хяналт хийж ажилласан.

ЗДТГ-ын “Гамшиг “-ийн дохио хvлээн авч ажиллах хотолбор боловсруулж ЗДТГ-ын даргаар батлуулан 1 удаа дадлага хийж хаягийн болон гар утасны дугааруудыг тодотгосон.

Цэргийн штабын тайлан 2013

Бичсэн .

2014 оны 3-р сарын 04, Мягмар гариг, 08:31 - Сvvлд шинэчлэгдсэн 2014 оны 3-р сарын 04, Мягмар гариг, 08:32

Дөрөв: Хугацаат болон гэрээт цэргийн албаны цэрэг татлагын талаар:

Батлан хамгаалах хууль тогтоомж, гэрээт цэргийн албыг орон нутагт сурталчилж, 1,2 дугаар ээлжийн цэрэг татлагын нарядыг 100% - тай биелvvлэн ангиудад бvрэн хвлээлгэж огч дvн мэдээг цаг хугацаанд нь хvргvүлсэн.

2013 оны 1 ,2 дугаар ээлжээр Зэвсэгт хvчний 123 дугаар ангид гэрээт цэргийн албанд 1 дvгээр зэргийн бэлтгэл vүрэгтэнг хуваарилан огч ЗХЖШ-аас огсон нарядыг 100% биелvvлсэн.

Зэвсэгт хvчний 123 дугаар ангид хувиарлан огсон гэрээт цэргийн алба хаагчид Зэвсэгт хvчний хэмжээнд явагдсан “Марш тактик тусгай бэлтгэлийн аварга шалгаруулах гэрээт цэргийн тасгийн тэмцээн”-д 2 дах удаагаа “Тэргvүн байр” эзэлж, 3 гэрээт цэргийн алба хаагч НҮБ-ын мандаттай Омнод Африкийн Бvгд найрамдах Судан Улсад энхийг дэмжих ажиллагаанд vүргээ амжилттай гvйцэтгэж ирсэн богоод vргэлжлvvлэн албаа хааж байна.

Цэрэг татлагын veэр овчиноор тэнцэхгvй байгаа цэргийн алба хаагчдыг эрvvлжvvлэх талаар Баруун бvсийн оношлогоо эмчилгээний тов болон сум орон нутгийн эмнэлэгvүдэд албан тоот огч хамтран ажиллаж байна.

Цэрэг татлагын veэр сум орон нутагт гэрээт цэргийн албыг сурталчлах, Батлан хамгаалах болон Зэвсэгт хvчний бодлогыг хэргжvvлэх чиглэлээр яриа таниулагыг тогтмол хийж хэвшсэн.

Тав. Цэргийн дvйцvvлэх албыг биеэр хаагчдын талаар:

Цэргийн штабын тайлан 2013

Бичсэн .

2014 оны 3-р сарын 04, Мягмар гариг, 08:31 - Сvvлд шинэчлэгдсэн 2014 оны 3-р сарын 04, Мягмар гариг, 08:32

2013 онд цэргийн дvйцvвлэх албанд 40 цэрэг авах ёстойг 1 дvгээр ээлжийн цэрэг татлагаар татаж Буянт, Доргон, Дарви, Манхан, Цэцэгт сумуудын орон нутгийн удирдлагын санал, цэргийн шинэчилсэн тоо бvртгэлээр огсон захиалгын дагуу 40 цэргийг хуваарилан огч алба хаалгаж, дvйцvвлэх албаны дайчдын vврэг гvйцэтгэлт, тэдний сургалтанд нь хяналт тавьж, vврэг даалгавраар тогтмол ханган ажиллаж байна.

2013 онд дvйцvвлэх албанд авах тоог 100 % биелvвлсэн.

Цэргийн дvйцvвлэх алба хааж байгаа иргэдийг орон нутгийн тор захиргааны мэдэлд ажиллуулснаар сум орон нутгийг хогжvвлэх, бvтээн байгуулалтын ажил, байгалийн гамшиг осол, гал тvймэр, вер, ган , зуд, хавар, намрын ажил овс хадлан бэлтгэх ажлуудыг шийдвэрлэн хийлгэхэд чухал vврэг гvйцэтгэж байгааг орон нутгийн удирдлагууд онцлон тэмдэглэж, ондроор vнэлэлт огч хамтран ажиллаж байна.

Одоо нийт 10 суманд 80 хvн цэргийн дvйцvвлэх алба хааж байна.

Алтай суманд 2012 оны 5 дугаар сард Говийн их дархан цаазат газрын “Б” хэсгийн хамгаалалтын захиргаатай хамтарч Тахь ус гэдэг газарт тахь сэргээн нутагшуулах бэлтгэл ажил хангах зорилгоор шон суулгаж, тор татах, сумын газар тариалан эрхлэлттэй холбогдуулан 150 га газар шон суулгаж, 1,4км газар тор татах ЗДТГ-ын даргаар ахлуулан 210 хоногт ажил хийж гvйцэтгэсэн байна.

Доргон суманд дvйцvвлэх алба хааж байгаа цэргvвд орон нутагт хууль бусаар алт ухаж байгаа газарт одор бvр томилж, харуул гаргаж уг вйл ажиллагааг таслан зогсоогоод байна.

2013 оны 6 дугаар сарын байдлаар тус аймгийн хэмжээнд цаг агаар болон байгалийн гамшгийн байдал тайван байгаа боловч цэргийн дvйцvвлэх албыг биеэр хааж байгаа иргэд сум орон нутагтаа дайчлагдан vвргээ биелvвлж байна.

Цаашид цаг агаарын ямарч нохцолд Онцгой байдлын алба, бусад газартай хамтарч ажиллаж, vврэг гvйцэтгэхэд бэлэн байна.

Цэргийн штабын тайлан 2013

Бичсэн .

2014 оны 3-р сарын 04, Мягмар гариг, 08:31 - Сvvлд шинэчлэгдсэн 2014 оны 3-р сарын 04, Мягмар гариг, 08:32

Ховд аймгийн цэргийн дvйцvвлэх алба хааж байгаа иргэд ямар нэг сахилгын зорчил дутагдал гаргаагvй, албаа сайн хааж байна.

Дvйцvвлэх албанаас орон нутагт товлорvүлсэн монгоноос 2013 оны 2 дугаар сард цэргийн штабын даргын унаажуулах зорилгоор аймгийн ИТХ-ын тогтоол, Засаг даргын захирамжаар орлогын Ланд крузер-80 машин авч ашиглаж байна.

Зургаа: Дайчилгааны бэлэн байдлын талаар:

Аймгийн болон сумын дайчилгааны толовлогоог цаг хугацаанд тодотгож, сум, албан байгууллагуудыг шалгаж даалгаваржуулан тусгай толовлогоогоор ажилласан.

Улсын дайчилгааг Ховд аймгийн ЗДТГ-ын санхvv торийн сангийн хэлтсийн дарга П.Амгаланбаатар хариуцаж хамтран ажилладаг.

Долоо. Хугацаат мэдээ, тайланг ирvүлсэн байдал:

Цэргийн шинэчилсэн тоо бvртгэл явуулсан мэдээ, тайлан, 1, 2 дугаар ээлжийн цэрэг татлагын мэдээ, Дайчилгааны бэлэн байдлын толовлогоонд тодотгол хийсэн огvүлбэр акт, Дайчилгааны бэлтгэл vүрэгтэнvүдтэй сургалт явуулсан огvүлбэр акт, зурагт тайлан, тэмдэглэлт баяруудыг тэмдэглэн онгорvүлсэн тайлан, гэрээт болон дvйцvүлэхээр алба хаагчдын мэдээ тайлан, монгон толборийн зарцуулалтын болон барагдуулсан мэдээ, тайлан, орон нутгийн стратегийн vнэлгээ, “Монгол цэрэг –Дэлхийн цэрэг” сэдэвт лекц явуулсан тайлан болон бусад шаардлагтай мэдээ тайланг БХЯ-ны стратеги бодлого, толовлолтийн газар, ЗХЖШ-ын бодлого стратегийн, толовлолтийн газарт болон бусад холбогдох газар хэлтэс, харъяалагдах байгууллага, албан газруудад цаг хугацаанд нь хvргvүлсэн.

2013 онд аймгийн ард иргэдээс ирсэн давхардсан тоогоор 416 хvний оргодол, санал хvсэлт хvлээн авч цэрэг татлагын вед цаг тухайд нь хуулийн хvрээнд асуудлыг

Цэргийн штабын тайлан 2013

Бичсэн .

2014 оны 3-р сарын 04, Мягмар гариг, 08:31 - Сvvлд шинэчлэгдсэн 2014 оны 3-р сарын 04, Мягмар гариг, 08:32

шийдвэрлэсэн ба 806 хvний архивын лавлагааны материалыг боловсруулан явуулж, 801 хvний архивын лавлагааг холбогдох архивуудаас авч иргэд вйлчлvvлсэн байна.

Арав: Цэргийн штабын 2013 оны 1 жилийн эцсийн вйл ажиллагааны vр дvнгийн внэлгээ:

Толовлогдсон ажлыг хэрэгжvvлэхийн тулд цэргийн штабын 2013 жилийн эцсийн байдлаар вйл ажиллагааны толовлогоонд тусгасан Засаг даргын захирамж, албан даалгавар боловсруулан холбогдох байгууллагуудад хvргэж биелэлтийг тооцож ажилласаны vр дvнд биелэлт 94 %-тай байгаа богоод цэргийн штабын офицерууд Засаг даргын Тамгын газартай байгуулсан гэрээний биелэлт “**Дvvрэн хангалттай**,” “**Маш сайн**” внэлгээтэй дvгнэгдсэн байна.

Арван нэг 1 дvгнэлт:

Ховд аймгийн Засаг даргын тамгын газрын цэргийн штаб нь 2013 оны байдлаар олноо тавьсан зорилго, зорилтоо бvрэн хэрэгжvvлсэн.

1. Цэргийн албыг хаагаагvй, хаягандаа байхгvй, ямар нэг шалтгаангvйгээр цэргийн албанаас зайлхийсэн этгээдийг анхан шатны бvртгэлд бvртгэж авах, торгуулийн хэлбэрийн арга хэмжээг нарийн дэс дараалалтай болгох заалтыг хуульчлах шаардлагатай саналыг холбогдох яам, газруудад уламжилсан.

2.Ховд аймагт хvнсний бvтээгдэхvн болон ШТМ внэ харьцангуй тогтвортой бус ондор байдаг ялангуяа мах, шатахуун, тvлш зэрэг нь тогтмол осож байдаг нь сургалт бэлтгэл явуулахад санхvv монгоний хvндрэлтэй байдаг нь тосовд хvндрэл учруулдаг.

Цэргийн штабын тайлан 2013

Бичсэн .

2014 оны 3-р сарын 04, Мягмар гариг, 08:31 - Сүүлд шинэчлэгдсэн 2014 оны 3-р сарын 04, Мягмар гариг, 08:32

ЦЭРГИЙН ШТАБ
